



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А185

Улаанбаатар хот

Ёс зүйн дэд хороо байгуулах
тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4, 10 дугаар зүйлийн 10.3, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдсантай холбогдуулан нийт албан хаагчдын олонхын дэмжлэг авсан Гадаадын иргэн, харьяатын газрын Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг хавсралтад дурдсанаар байгуулсугай.

2.Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг төв болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн хэмжээнд зохион байгуулахыг Ёс зүйн дэд хороо (Н.Дуламсүрэн)-д даалгасугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан 2020 оны "О.Одгэрэл, Б.Анхбаяр нарыг Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийн гишүүнээр томилох тухай" Б/359 дүгээр тушаал, 2021 оны "О.Ганзориг, Ц.Пүрэвсүрэн нарыг Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийн гишүүнээр томилох тухай" Б/140 дүгээр тушаал, 2022 оны "Ёс зүйн зөвлөлийн зарим гишүүдийг томилох тухай" Б/237 дугаар тушаал, "Ёс зүйн зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргыг томилох тухай" А/174 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (И.Баатархүү)-т даалгасугай.

ДАРГА




Н.УУГАНБАЯР

D:/2023/2024/Tushaal2024.Doc

172400386

Гадаадын иргэн, харьяатын газрын
даргын 2024 оны 02 дугаар сарын 11-ны
өдрийн 118 дугаар тушаалын хавсралт



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:

Зөрчил шалган шийдвэрлэх газрын зөрчил
хариуцсан хяналтын улсын ахлах байцаагч
Н.Дуламсүрэн

Гишүүд:

Захиргаа, удирдлагын газрын хүний нөөц, сургалт
хариуцсан ахлах мэргэжилтэн
В.Шоовдор

Захиргаа, удирдлагын газрын орон нутаг хариуцсан
ахлах мэргэжилтэн
С.Мөнхтүвшин

Виз, зөвшөөрлийн газрын оршин суух хариуцсан
ахлах мэргэжилтэн
Г.Ганчимэг

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтсийн
нийцлийн аудит хариуцсан ахлах мэргэжилтэн
Ц.Пүрэвсүрэн

Хангалт, үйлчилгээний хэлтсийн цахилгаанчин
О.Ганзориг

Нарийн бичиг:

Захиргаа, удирдлагын газрын хувийн хэрэг
хариуцсан хүний нөөцийн мэргэжилтэн
Ш.Дэмбэрэлдулам